



*МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН*  
**2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

*2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ*

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС**

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр, Даваа гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-6

---

- 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/* 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 5 дугаар сарын 29-ний өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: Ж.Батсуурь, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа, Д.Өнөрболор, Б.Чойжилсүрэн.*

***Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 10 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 31 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 21 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Ганибалын Амартүвшин, Цогт-Очирын Анандбазар, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн, Чимэдийн Хүрэлбаатар нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 4 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн сайд Б.Жавхлан байхгүй байна. Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. М.Санжаадорж байхгүй байна уу?

Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Б.Сүх-Очир Санхүүгийн бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Байгалмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Ингээд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай

танилцуулгыг бэлтгэн Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрс авъя. Ж.Батжаргал гишүүнээр тасалъя.

Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллөө дэмжиж байгаа юм. Тэгээд ганцхан тоон дээр асуудал байгаа юм.

Эртээд саналын зөрүүтэй саналын томьёолол гаргаад уначихсан.

Бодит байдалтайгаа бид нийцсэн тоонууд тавимаар санагдаад байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөө 6.5 гээд бид 65 орчим их наядын үйлдвэрлэлтэй байхаар юм шиг байна.

Гэтэл Засгийн газрын гадаад өр маань өнөөдрийн байж байгаа байдал нь 51 хувьтай байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ. Тэгээд одоо хуулийн дээд хязгаараар 60 гэж тавьчхаад байгаа юм.

Тэгэхээр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт талаасаа харж үзэх юм бол энэ чинь бараг 4.2 их наяд орчим төгрөгөөр өсөлт нь өөрөө гарч ирж байгаа.

Тэгэхээр одоогийн байж байгаа 51-ээ бариад явчих бололцоо байгаад байгаа. Энэ нийгмийн сэтгэл зүйн уур амьсгал чинь Монгол Улсын өр, Засгийн газрын өр, энэ тусгай сангуудын өр зээл,

луйврын асуудлаар үнэхээрийн сэтгэл эмзэглэлтэй байна.

Тийм учраас заавал хуулийн хязгаарт байж болох дээд хязгаараар тоо тавьчхаад яваад байх нь зөв юм уу? Үүнийгээ бодит байдалдаа тооцооллоо хийгээд тавьчхаач ээ. Ард түмэнд их бодитой мэдээллийг нь өгчхөөч гэхээр зэрэг шийдэл нь гарч өгөхгүй л байгаад байна л даа.

Тийм учраас үүнийг би зориуд өнөөдрийн хуралдааны тэмдэглэлд нь үлдээе гэж бодож зориуд энэ асуултыг асууж байгаа юм. Энэ дээр манай нөхөд ямар бодол, байр суурь байгаад байгаа юм бэ?

**Г.Тэмүүлэн:** Асуултад хариулъя. 6 номер. Ж.Ганбат дарга.

**Ж.Ганбат:** Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын өр өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дотоод үнэтэй эзлэх харьцаа 2022 онд 52.4 хувьд байсан бол 2023 онд 51.2, 2024 онд 42-той тэнцэх ийм суурь төсөөлөлтэй байгаа.

Хөгжлийн банкны 2023 оны 10 сард төлөгдөх евро бондын дахин санхүүжилт баталгаа гаргах тохиолдолд 2023 онд 54.3, 2024 онд 51.9 хувьтай тэнцэх ийм урьдчилсан тооцооллыг бид хийгээд байгаа.

Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа төсвийн хүрээний хязгаараар 60 хувь, 2024 онд 39.3 их наядтай, 60 хувь буюу 2020 онд 39.3 их наяд төгрөгтэй тэнцүү байх хязгаартай байгаа.

Тэгээд төсвийн сахилга баттай байж шинээр баталгаа гаргахгүй байх тохиолдолд 32 их наядад дотоодын нийт бүтээгдэхүүн 49 хувьд хүрч энэ 50-иас доош орох ийм тооцоолол байгаа.

Гэхдээ бидний тооцож байгаагаар яах вэ, ханшийн хэлбэлзэл байна.

Нөгөө талдаа “Шинэ сэргэлт”-ийн бодлогын төслүүдийг явуулж байгаа учраас үүнтэй холбогдуулан бид яах вэ, орон зайгаа хэт хатуу заагаад өгчихөөр бид дараа нь энэ асуудал дээрээ бас орон зайгүй гацчих болов уу гэж бодоод.

Нэгэнт хуулийн хязгаараараа боломж байгаа учир тэр дээд хязгаараар нь төсвийн хүрээний мэдэгдэлдээ тавиад явбал яасан юм бэ гэдэг ийм л байр суурьтай байгаа.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу?  
Ж.Батжаргал гишүүн.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Тэгэхээр саяын энэ асуудал дээр ч гэсэн бас Сангийн яам анхаарч ажиллах ёстой шүү.

Одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар 10 сарын 01-нд 2024 оны төсвийг оруулж ирнэ.

Жил жилийн төсвийг өргөн барьж оруулж ирэхдээ 10 сарын 01-дээ тулгаж орж ирдэг байдлаасаа салах ёстой шүү.

Долоо хоногийн өмнө ч, 10 хоногийн өмнө ч, хоёр долоо хоногийн өмнө ч та бүхэн хуулийнхаа төслийг дууссан бол өргөн бариад, танилцуулаад мэдээлжих эрхээр иргэдийг ч болоод Улсын Их Хурлыг хангах ёстой шүү.

Энэ асуудал дээр анхаарах ёстой.

Бидний хувьд төсвийг төсөвлөхдөө хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, дээрээс нь төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах дээр онцгой анхаарах ёстой гэдэг асуудлыг олон жил ярьж байгаа.

Энэ ч хүрээнд нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд төсвийн шинэчлэлийн хуулийн төслүүдийг өргөн барьсан.

Энэ хуулийг энэ хавартаа бид эцэслэж батлахаар төлөвлөөд явж байгаа. Өргөн барьсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад хэд хэдэн анхаарах асуудлууд байгаа.

Сая Ж.Батжаргал гишүүний хэлж байгаа асуудлууд байна.

Дээрээс нь орлогыг зөв тооцоолох, нягтлах шаардлагатай байна. Оюу Толгойн далд уурхайн олборлолт нэмэгдэж байгаа гэдэг асуудлыг оруулж ирж байгаа.

Зэсийн баяжмал дахь алтных нь агууламж нь нэмэгдэж байгаа. Тийм ээ.

2024 онд Оюу Толгойгоос олборлох хүдэр дотор нь агуулагдаж байгаа алтных нь агууламж нь 6 тонн, 2025 онд 14 тонн гэж байгаа юм.

Тэгэхээр энэ орлогынхоо тооцоолол дээр та бүхэн анхаарч үзээрэй. Тооцооллоо нягтлаарай.

Хэрэв энэ тэнцвэржүүлсэн орлогоор тооцогдохоор байгаа бол тооцогдох ёстой орлогуудыг төсөв өргөн барьж ирэхдээ оруулж ирэх ёстой.

Ингэж байж “Ирээдүй өв сан” дээр орлого хуримтлагдах, цаашдаа хуримтлал бий болох боломж боллоцоо бий болно шүү.

Тооцоолол дээр онцгой анхаарч үзээрэй гэдэг асуудлыг тавих байна.

Дээрээс нь нэг талдаа бид 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлээр зардлыг 12.3 хувиар нэмэгдэж орж ирж байна.

Үүн дотроо бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбогдуулан цалин, хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх, тэгшитгэх арга хэмжээг нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байгаа.

Энэ асуудал дээр та бүхэн онцгой анхаарч үзээрэй.

Цааш цаашдаа бид төсвийн тогтвортой байдлынхаа хуулийг мөрдөж ажиллах ёстой.

2024 оны төсөв дээр одоо батлагдаж байгаа төсвийн хүрээнээс давсан байдлаар тооцооллыг оруулж ирэх, төсвийн хүрээний мэдэгдэл дээр өөрчлөлт оруулах асуудлыг нэг талдаа хүлээн зөвшөөрөхгүй. Батлагдсан хүрээндээ батлагдсан хуулийнхаа хүрээнд, мэдэгдлийнхээ хүрээнд ирэх оныхоо төсвийг барьж оруулж ирнэ.

Олон жилийн хугацаанд бид жилдээ хоёроос гурван удаа төсвийнхөө хүрээний мэдэгдэл дээр өөрчлөлт оруулдаг байсан.

10 жилд 10 удаа батлагдах ёстой байсан төсвийн хүрээний мэдэгдэл 23 удаа батлагдсан байгаа. Энэ ч байдлаасаа үүдээд Засгийн газрын өр сүүлийн жилүүд энэ 60 хувиасаа буухгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн онцгой анхаарч ажиллаарай гэдгийг чиглэл болгож хэлж байна.

Ингээд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Ц.Сандаг-Очир гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулах уу? Ц.Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд бас баярлалаа.

*Хуралдаан 10 минут үргэлжилж, 10 цаг 31 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**